МЭДЭЭ · 2026 оны 3-р сарын 23

АЛБАН ТУШААЛТАН 350 САЯ ТӨГРӨГ ЗАВШСАН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 20-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 48,116 эрүүгийн хэрэгт хяналт тавин ажиллажээ.

Дээрх хугацаанд 1,398 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол хэрэг бүртгэлтийн 566 хэрэг шинээр нээж, 304 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдсэн байна.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 120, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 73, Өмчлөх эрхийн эсрэг 64, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 13, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 10, Хүний амьд явах эрхийн эсрэг болон Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг тус бүр 8, Авлигын гэмт хэрэг 5, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг, Кибер аюулгүй байдлын эсрэг, Эдийн засгийн гэмт хэрэг тус бүр 1 яллах дүгнэлт үйлдсэн байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 120 гэмт хэргийг зүйлээр нь авч үзвэл, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан 8, хүндэвтэр хохирол санаатай учруулсан 11, хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулсан 1, хүний эрүүл мэндэд

хөнгөн хохирол учруулсан 97, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 3 хэрэг байна.



Нийслэлийн прокурорын газраас шүүхэд шилжүүлсэн хэргээс дурдвал:

- Ж.Б нь ..... газрын ....төв лабораторийн шинжилгээ хариуцсан ахлах шинжээчээр ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, О.Б, Б.О, Ж.Н, Ж.М, Д.А нартай бүлэглэн шинжилгээ хийх нэрийдлээр үнийн саналыг өөрчлөн, тайланг хуурамчаар гаргуулж, төрийн сангаас нэр бүхий хуулийн этгээдийн данс руу 428,4 сая төгрөгийг шилжүүлж, улмаар өөрийн данс руу 350 сая төгрөгийг шилжүүлэн авч, төсвийн хөрөнгийг хувьдаа завшсан хэрэгт Эрүүгийн хуулийн 17.4 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дах хэсэг (Завших) -т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд;

- М.О нь Монгол Улсад худалдаалах зөвшөөрөлгүй, Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, гадаад улсад үйлдвэрлэсэн эмийг улсын хилээр нэвтрүүлсэн, худалдан борлуулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (Хууль бусаар эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх, худалдах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд;

- Э.Э нь өөрөө хэрэглэх зорилгоор НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенцын II жагсаалтад багтсан (delta-9-tetrahydrocannabinol) бодисын агууламжтай ургамлыг худалдаалах зорилгогүйгээр түүж бэлтгэсэн, хадгалсан, мөн 1971 оны “Мансууруулах эмийн тухай” конвенцын II жагсаалтад багтсан (methamphetamine) агууламжтай бодисыг хууль бусаар олж авч, хадгалсан хэрэгт Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд тус

тус шилжүүллээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/654